

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2025/110/НА-СТА-ТШЗ

| | |
|--|---|
| Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2025 он | Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Аудитор: Э.Сүнжидмаа Утас: 80048599 Цахим хаяг: sunjidmaae@audit.gov.mn Аудитор: А.Цэням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyam1202@gmail.com |
|--|---|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ГАА-2025/110/НА-СТА-ТШЗ

Агуулга

| | |
|--|-----------|
| 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ | 2 |
| ХОЁР:АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ..... | 5 |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан | 5 |
| 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан | 6 |
| 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан | 7 |
| 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан | 8 |
| 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан | 8 |
| ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ | 9 |
| Залруулсан алдаа..... | 9 |
| Төлбөрийн акт..... | 10 |
| Албан шаардлага | 11 |
| Зөвлөмж | 14 |
| дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ..... | 16 |
| ТАВ. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ | 20 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402 Хөгжил хөрөндөл Жинст баг
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: (976) 70 48 34 13
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2025.02.24

№

93

Танай

Чинь №

ХТ

ЭРДЭНЭ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Т.ОРГИЛМАА ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.4, 16.5.5 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, 15 дугаар зүйлийн 15.1.3, 15.1.5 дахь заалт Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал хавсралт "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалттай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, үнэн зөв, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Засаг даргын нөөц хөрөнгөнөөс эрдэм шинжилгээний хурлын эх бэлтгэл, ойн эмхэтгэл хийх, улс, аймгийн аварга малчдад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ, соёлч өрхийн шагнал, аймгийн аварга шалгаруулах тэмцээнд оролцсон тамирчдын дэмжлэг, нутгийн зөвлөлийн золгуут хийх, ойн арга хэмжээнд цагаан идээ худалдан авах зэрэгт 42,697.1 мянган төгрөгийг үр ашиггүй зарцуулсан.

8225920336

- Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас төсөвт төлөвлөөгүй атлаа ажилтнуудыг БНХАУ-ын Жинин хотод туршлага судлах арга хэмжээнд 8,250.0 мянган төгрөгийг зарцуулсан.
- Ажиллагсдад олгосон урьдчилгаа цалин суутгаагүй, хоолны мөнгийг илүү олгосон, өмнөх оны авлага суутгаагүй зэрэг нийт 5,432.2 мянган төгрөгийн зөрчил илэрсэн.
- Хөрөнгөд бүртгэлтэй Land 100 маркийн ГАА80-52 улсын дугаартай автомашины моторын ээлж солих ажлын хөлс, сэлбэг, урсгал засварт 21,000.0 мянган төгрөгийг өмч хамгаалах зөвлөлийн шийдвэргүй зарцуулсан.
- Сумын 100 жилийн ойн арга хэмжээний арга хэмжээний зардлаас хүндэтгэлийн хүлээн авалтын арга хэмжээг гүйцэтгүүлэх гэрээ байгуулан 48,300.0 мянган төгрөгийг олгоод зарцуулалтад бүрэн хяналт тавьж ажиллаагүй зэрэг нийт 125,679.3 мянган төгрөгийн зөрчил илэрч, санхүүгийн тайланд авлага, өглөг тусгаагүй, үнэ төлбөргүй ирсэн хөрөнгийг орлогод бүрэн тусгаагүй зэрэг 230,496.3 мянган төгрөгийн алдааг залруулсан.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд 100 жилийн ой тохиож орон нутгийн төсвөөс сумын түүхт 100 жилийн ойн арга хэмжээнд 100,000.0 мянган төгрөгийг хүлээн авснаас 48,300.0 мянган төгрөгийг хүндэтгэлийн хүлээн авалтын арга хэмжээ, зочдын хоол хүнсэнд, 22,652.4 мянган төгрөгийг урсгал засварын зардалд, 10,569.5 мянган төгрөгийг тохижилтод, 6,670.0 мянган төгрөгийг ойн медаль авахад, 4,600.0 мянган төгрөгийг сэлбэг хэрэгсэл худалдан авахад тус тус зарцуулсан байна.

Иргэд, байгууллагаас 108,714.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хандиваар, 962,791.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бусад эх үүсвэрээс шилжүүлэн авч, 13,593.0 мянган төгрөгийн бараа материалыг хандиваар хүлээн авч бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Орон нутгийн төсвөөс 1,158,691.3 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөснөөс 14,300.0 мянган төгрөгийг дутуу олгосон байна.

Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах журмаар шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг олгох бүрэн эрхийг Засаг даргад олгосон боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулиар дээрх арга хэмжээний зардлыг зарцуулахыг хориглосон байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Тайлант онд 1 хөтөлбөр, 8 зорилт, 160 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 113 арга хэмжээг бүрэн, 26 арга хэмжээ 70 хувьтай, 17 арга хэмжээг 50 хувьтай, 6 арга хэмжээ 30 хувьтай нийт дундаж дүнгээр 89.6 хувиар үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

ХОЁР:АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------------|---|-------------------------|-------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 157,870,790.27 | 196,669,040.27 |
| 33 | АВЛАГА | 2,024,420.00 | 8,024,420.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 408,000.00 | 408,000.00 |
| 335 | Бусад авлага | 1,616,420.00 | 7,616,420.00 |
| 33510 | Байгууллагаас авах авлага | - | 6,000,000.00 |
| 33520 | Хувь хүмүүсээс авах авлага | 1,616,420.00 | 1,616,420.00 |
| 34 | УРЬДЧИЛГАА | 1,500,000.00 | 1,500,000.00 |
| 3471 | Урьдчилгаа тооцоо | 1,500,000.00 | 1,500,000.00 |
| 34713 | Цалингийн урьдчилгаа | 1,500,000.00 | 1,500,000.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 154,346,370.27 | 187,144,620.27 |
| 351 | Түүхий эд материал | 2,498,600.00 | 11,263,600.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 2,498,600.00 | 11,263,600.00 |
| 354 | Хангамжийн материал | 47,857,770.27 | 71,891,020.27 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,537,600.00 | 2,758,600.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 25,273,951.25 | 47,519,201.25 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 3,281,500.00 | 4,848,500.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 1,473,600.00 | 1,473,600.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 15,291,119.02 | 15,291,119.02 |
| 35600 | Мал амьтад | 103,990,000.00 | 103,990,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 3,564,860,308.27 | 4,528,902,667.09 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 3,564,860,308.27 | 4,528,902,667.09 |
| 392 | Биет хөрөнгө | 2,330,223,628.27 | 3,294,265,987.09 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,492,630,629.44 | 3,520,467,474.89 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (556,277,692.77) | (693,418,630.62) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 230,743,400.00 | 227,753,400.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (160,942,599.67) | (164,336,133.10) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 123,499,555.04 | 160,316,155.04 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (84,632,064.73) | (101,702,796.49) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 48,727,025.60 | 87,593,025.60 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (20,699,727.35) | (33,710,057.38) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 143,701,762.00 | 143,701,762.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (33,851,383.17) | (40,216,671.33) |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 10,000,000.00 | 10,000,000.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 206,760,991.00 | 277,660,991.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (69,436,267.12) | (99,842,532.52) |
| 393 | Биет бус хөрөнгө | 1,234,636,680.00 | 1,234,636,680.00 |
| 39301 | Програм хангамж | 9,402,680.00 | 9,402,680.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | - | - |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 1,225,234,000.00 | 1,225,234,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | - | - |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 3,722,731,098.54 | 4,725,571,707.36 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | - | 42,108,842.40 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | - | 42,108,842.40 |
| 413 | Өглөг | - | 42,108,842.40 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | 40,621,438.11 |
| 4136 | Бусад өглөг | - | 1,487,404.29 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 1,487,404.29 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 3,722,731,098.54 | 4,683,462,864.96 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 3,722,731,098.54 | 4,683,462,864.96 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 196,494,040.37 | 196,494,040.37 |
| 51101 | Өмч: - төрийн | 196,494,040.37 | 196,494,040.37 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 3,321,624,291.74 | 4,282,356,058.16 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 3,321,624,291.74 | 3,321,624,291.74 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 960,731,766.42 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 204,612,766.43 | 204,612,766.43 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 3,722,731,098.54 | 4,725,571,707.36 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|------------------------|-------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 2,286,834,749.0 | 2,409,989,217.45 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1,461,844,524.0 | 1,085,098,910.45 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 1,461,844,524.0 | 1,085,098,910.45 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 1,461,544,524.0 | 1,071,505,910.45 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 300,000.0 | 13,593,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 824,990,225.0 | 1,324,890,307.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 86,400,025.0 | 180,499,007.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 80,216,025.0 | 177,508,007.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 6,184,000.0 | 2,991,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 738,590,200.0 | 1,144,391,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 738,590,200.0 | 1,144,391,300.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 1,170,599,245.3 | 1,449,257,451.03 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,170,599,245.3 | 1,449,257,451.03 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,124,707,795.9 | 1,339,443,054.89 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 348,347,218.3 | 607,425,737.82 |
| 210101 | Үндсэн цалин | 240,225,959.3 | 378,467,768.54 |
| 210102 | Нэмэгдэл | 84,669,719.6 | 190,193,501.99 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 8,589,290.7 | 10,218,983.39 |
| 210104 | Урамшуулал | 14,862,248.7 | 28,545,483.90 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 43,698,886.4 | 76,062,859.85 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 29,732,065.5 | 51,638,176.91 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,491,705.1 | 6,075,079.66 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,793,364.3 | 3,161,904.16 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 698,341.1 | 3,037,539.83 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,983,410.5 | 12,150,159.29 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 105,404,283.1 | 128,815,548.59 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,871,433.1 | 15,411,228.59 |
| 210302 | Түлш, халаалт | 97,603,850.0 | 108,328,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,929,000.0 | 5,076,320.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 72,690,172.0 | 79,295,577.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,007,780.0 | 6,283,925.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 60,663,392.0 | 65,814,252.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,222,200.0 | 1,376,500.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 3,000,000.0 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 180,000.0 | 598,400.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,616,800.0 | 5,222,500.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 26,985,200.0 | 10,996,750.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,615,000.0 | 175,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 24,370,200.0 | 10,821,750.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 11,004,000.0 | 10,956,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 11,004,000.0 | 10,956,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 29,003,709.0 | 18,707,295.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 25,356,500.0 | 15,794,100.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 428,100.0 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 466,628.0 | - |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 132,000.0 | 121,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 720,000.0 | 1,044,800.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,900,481.0 | 1,747,395.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 487,574,327.3 | 407,183,286.63 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 97,890,307.0 | 174,522,200.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,610,000.0 | 5,284,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 388,074,020.3 | 227,377,086.63 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 45,891,449.3 | 109,814,396.14 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 6,638,750.0 | 89,113,800.60 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | - | 35,635,144.60 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 29,531,156.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 6,638,750.0 | 23,947,500.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 39,252,699.3 | 20,700,595.54 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 39,252,699.3 | 20,700,595.54 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 1,116,235,503.7 | 960,731,766.42 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 1,116,235,503.7 | 960,731,766.42 |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|-----------------------|-------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 824,990,225.00 | 1,324,890,307.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 824,990,225.00 | 1,324,890,307.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 86,400,025.00 | 180,499,007.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 80,216,025.00 | 177,508,007.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлого | 6,184,000.00 | 2,991,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 738,590,200.00 | 1,144,391,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 738,590,200.00 | 1,144,391,300.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 824,990,225.00 | 1,204,976,772.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 824,990,225.00 | 1,204,976,772.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 779,098,775.67 | 1,095,162,375.86 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 349,247,218.26 | 577,445,500.00 |
| 210101 | Үндсэн цалин | 241,125,959.28 | 348,487,530.72 |
| 210102 | Нэмэгдэл | 84,669,719.59 | 190,193,501.99 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 8,589,290.72 | 10,218,983.39 |
| 210104 | Урамшуулал | 14,862,248.67 | 28,545,483.90 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 43,698,886.37 | 65,421,659.56 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 29,732,065.46 | 45,523,271.67 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,491,705.07 | 4,950,994.48 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,793,364.27 | 2,569,907.24 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 698,341.12 | 2,475,497.24 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,983,410.45 | 9,901,988.93 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 105,454,283.08 | 128,329,644.30 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,871,433.08 | 14,925,324.30 |
| 210302 | Түлш, халаалт | 97,603,850.00 | 108,328,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,979,000.00 | 5,076,320.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 76,103,872.00 | 80,397,627.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,007,380.00 | 7,064,925.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 60,663,392.00 | 64,812,752.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,222,200.00 | 1,376,500.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 3,000,000.00 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 180,000.00 | 598,400.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7,030,900.00 | 6,545,050.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 49,306,700.00 | 14,771,750.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 22,225,000.00 | 405,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 27,081,700.00 | 14,366,750.00 |
| 2107 | Томиллот, зочны зардал | 11,004,000.00 | 10,956,000.00 |
| 210702 | Дотоод албан томиллот | 11,004,000.00 | 10,956,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 44,001,008.96 | 24,707,295.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр | 40,353,800.00 | 21,794,100.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 428,100.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 466,627.96 | - |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 132,000.00 | 121,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 720,000.00 | 1,044,800.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,900,481.00 | 1,747,395.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 100,282,807.00 | 193,132,900.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 98,332,807.00 | 187,848,900.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,950,000.00 | 5,284,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 45,891,449.33 | 109,814,396.14 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 6,638,750.00 | 89,113,800.60 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | - | 35,635,144.60 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 29,531,156.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 6,638,750.00 | 23,947,500.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн олгох татаас, санхүүжилт | 39,252,699.33 | 20,700,595.54 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 39,252,699.33 | 20,700,595.54 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | = | 119,913,535.00 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | = | 119,913,535.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | = | 119,913,535.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | = | 119,913,535.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | 119,913,535.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | = | (119,913,535.00) |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|-----|----------------------------|---------------------------------|-----------------------|-------------------|--|
| C01 | 2023.01.01-нээрх үлдэгдэл | 196,494,040.37 | 204,612,766.43 | 2,205,388,788.00 | 2,606,495,594.80 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 196,494,040.37 | 204,612,766.43 | 2,205,388,788.00 | 2,606,495,594.80 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 1,116,235,503.74 | 1,116,235,503.74 |
| C08 | 2023.12.31-нээрх үлдэгдэл | 196,494,040.37 | 204,612,766.43 | 3,321,624,291.74 | 3,722,731,098.54 |
| D01 | 2024.01.01-нээрх үлдэгдэл | 196,494,040.37 | 204,612,766.43 | 3,321,624,291.74 | 3,722,731,098.54 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 196,494,040.37 | 204,612,766.43 | 3,321,624,291.74 | 3,722,731,098.54 |
| D09 | 2024.12.31-нээрх үлдэгдэл | 196,494,040.37 | 204,612,766.43 | 4,197,039,881.92 | 4,598,146,688.72 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|-----------------------|--|-----------------------|-----------------|----------------|--------|
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,158,691,300.0 | 1,127,450,469.5 | 31,240,830.50 | 97.30 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,158,691,300.0 | 1,127,450,469.5 | 31,240,830.50 | 97.30 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,049,619,000.0 | 1,038,336,668.9 | 11,282,331.10 | 98.93 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 577,445,500.0 | 577,445,500.0 | 0.00 | 100.00 |
| 210101 | Үндсэн цалин | 577,445,500.0 | 348,487,530.7 | 228,957,969.30 | 60.35 |
| 210102 | Нэмэгдэл | - | 190,193,502.0 | 0.00 | 0.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 10,218,983.4 | 0.00 | 0.00 |
| 210104 | Урамшуулал | - | 28,545,483.9 | 0.00 | 0.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 72,000,000.0 | 65,421,659.6 | 6,578,340.40 | 90.86 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 50,320,000.0 | 45,523,271.7 | 4,796,728.30 | 90.47 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,600,000.0 | 4,950,994.5 | 649,005.50 | 88.41 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,680,000.0 | 2,569,907.2 | 110,092.80 | 95.89 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,680,000.0 | 2,475,497.2 | 204,502.80 | 92.37 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,720,000.0 | 9,901,988.9 | 818,011.10 | 92.37 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 129,100,000.0 | 128,329,644.3 | 770,355.70 | 99.40 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 14,400,000.0 | 14,925,324.3 | -525,324.30 | 103.65 |
| 210302 | Түлш, халаалт | 108,700,000.0 | 108,328,000.0 | 372,000.00 | 99.66 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,000,000.0 | 5,076,320.0 | 923,680.00 | 84.61 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 74,141,500.0 | 73,612,245.0 | 529,255.00 | 99.29 |
| 210401 | Бичиг хэрэг | 7,464,000.0 | 7,064,925.0 | 399,075.00 | 94.65 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 58,578,500.0 | 58,517,370.0 | 61,130.00 | 99.90 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,400,000.0 | 1,376,500.0 | 23,500.00 | 98.32 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 600,000.0 | 598,400.0 | 1,600.00 | 99.73 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,099,000.0 | 6,055,050.0 | 43,950.00 | 99.28 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 54,000,000.0 | 53,212,350.0 | 787,650.00 | 98.54 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 23,000,000.0 | 22,261,600.0 | 738,400.00 | 96.79 |
| 210604 | Урсгал засвар | 31,000,000.0 | 30,950,750.0 | 49,250.00 | 99.84 |
| 2107 | Томиллолт, зочны зардал | 11,120,000.0 | 10,956,000.0 | 164,000.00 | 98.53 |
| 210702 | Дотоод албан томиллолт | 11,120,000.0 | 10,956,000.0 | 164,000.00 | 98.53 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 30,192,000.0 | 28,340,295.0 | 1,851,705.00 | 93.87 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 25,500,000.0 | 25,427,100.0 | 72,900.00 | 99.71 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 172,000.0 | - | 0 | 0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 800,000.0 | - | 0 | 0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 400,000.0 | 121,000.0 | 279,000.00 | 30.25 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,320,000.0 | 1,044,800.0 | 275,200.00 | 79.15 |
| 210807 | Газрын төлбөр | 2,000,000.0 | 1,747,395.0 | 252,605.00 | 87.37 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 101,620,000.0 | 101,018,975.0 | 601,025.00 | 99.41 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 96,300,000.0 | 95,734,975.0 | 565,025.00 | 99.41 |

Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

| | | | | | |
|-------------|---|-----------------|-----------------|---------------|----------|
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,320,000.0 | 5,284,000.0 | 36,000.00 | 99.32 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 109,072,300.0 | 89,113,800.6 | 19,958,499.40 | 81.70 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 109,072,300.0 | 89,113,800.6 | 19,958,499.40 | 81.70 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 53,231,000.0 | 35,635,144.6 | 17,595,855.40 | 66.94 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 31,841,300.0 | 29,531,156.0 | 2,310,144.00 | 92.74 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 24,000,000.0 | 23,947,500.0 | 52,500.00 | 99.78 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 1,158,691,300.0 | 1,127,450,469.5 | 31,240,830.50 | 97.30 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,158,691,300.0 | 1,127,450,469.5 | 31,240,830.50 | 97.30 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 1,158,691,300.0 | 1,127,450,469.5 | 31,240,830.50 | 97.30 |
| 62 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 26 | 23 | 3 | - |
| 620001 | Удирдах ажилтан | 7 | 7 | - | - |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 14 | 14 | - | - |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 1 | 1 | - | - |
| 620004 | Гэрээт ажилтан | 4 | 1 | 3 | - |

ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 230,496.3 мянган төгрөгийн 14 алдаа¹ -г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:

- Нийгмийн даатгалын хэлтэст төлөх шимтгэлийн өглөг 33,641.мянган төгрөгийг санхүүгийн тайланд тусгаагүй.
- Ажиллагсдын цалингаас суутган тооцсон ХХОАТ-ийн 6,980.0 мянган төгрөгийг дутуу төлж тайланд өглөгөөр тусгаагүй.
- Алтай Улайстай Эрчим хүчний систем ТӨХК-д цахилгааны 12 дугаар сарын төлбөрийг нэхэмжилсэн 1487.4 мянган төгрөгийг төлөөгүй, тайланд өглөгөөр тусгаагүй.
- Агнуур судлалын нийгэмлэг нь "Агнуурын менежментийн төлөвлөгөөг шинэчлэх ажлыг гүйцэтгэх" гэрээний дагуу 6,000.0 мянган төгрөгийг урьдчилан гарсан зардлаар бүртгээгүй.
- Хансан панзат ХХК-ын ариун цэврийн байгууламжийн төлбөрийг гэрээний дагуу 24,995.6 мянган төгрөгийг бүрэн төлсөн байхад тайланд 7,458.7 мянган төгрөгийн өмнөх онд төлсөн мөнгөн дүнгээр өглөгтэйгээр тайлагнасан,
- Сумын орон нутгийн хөгжлийн сангаас хөрөнгөөр худалдан авсан 9,700.0 мянган төгрөгөөр унаач хүүхдүүд, бөхийн засуулын хувцсыг тусгай зориулалтын бараа материалд бөөн дүнгээр бүртгэсэн.
- Шатахууны орлогоос 6,217.2 мянган төгрөгийн орлогыг тайланд бөөн дүнгээр тайланд тусгасан,
- Сэлбэг материалын дансанд барилгын материалыг орлого авч зарлага гаргаж санхүүгийн тайлангийн мэдээллийг буруу илэрхийлсэн,
- Худалдан авсан 8,000.0 мянган төгрөгийн төмөр 4 самбарыг үндсэн хөрөнгөд бүртгээгүй, тусгай зориулалтын бараа материалын дансанд орлогоор бүртгэсэн,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

- Нэмэлт санхүүжилтийн данснаас Мөнгөн тахилт ХХК-д илүү шилжүүлсэн 400.0 мянган төгрөгийг буцааж дансанд орж ирсэн мөнгийг МГ, ҮД-ийн тайланд орлогоор бүртгэж, тайланг буруу илэрхийлсэн,
- Хөрөнгийн бүртгэлд бүртгэлтэй Land 100 ГАА80-52 автомашины моторын ээлж сольж, засвар үйлчилгээ хийлгэхэд нийт 17,000.0 мянган төгрөгийг зарцуулсан ч тайланд өртгийг нэмэгдүүлэн капиталжуулж бүртгээгүй зардлаар тайлагнасан,
- Сумын 100 жилийн ойгоор иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас хандивласан жагсаалтаар хүлээн авсан 83,946.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг тайланд орлого аваагүй.
- Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас эрх шилжиж ирсэн хөрөнгө оруулалтын оролцооны 28,000.0 мянган төгрөгийн 2 худгийг хөрөнгөд орлого авахдаа бусад үнэ төлбөргүй орлогоор бүртгэж, тайланд орлого зардлыг нэмэгдүүлэн буруу тайлагнасан.
- Дүзо Назо ХХК-тай үүссэн халаалтын зардлын нэхэмжилсэн, тооцоо нийлж актаар баталгаажуулсан 21,665.6 мянган төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг зөрчсөн.

Залруулагдаагүй нийт 137,807.4 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 137,807.4 мянган төгрөгийн 12 зөрчил² илэрч 9,282.1 мянган төгрөгийн 4 төлбөрийн акт, 128,525.2 мянган төгрөгийн 6 зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх албан шаардлага, 2 зөвлөмжийг хүргүүллээ.

Төлбөрийн акт

1. Ажиллагсад олгосон урьдчилгаа цалингаас 500,0 мянган төгрөгийг дутуу суутгасан, өмнөх оны цалингийн урьдчилгааны 1,500.0 мянган төгрөгийг суутган тооцоогүй, ажилтнаас авах 2,024.4 мянган төгрөгийн нөхөн төлбөрийг төсөвт төвлөрүүлээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Албан томилолтоор ажилласан албан хаагчдад 567.0 мянган төгрөгийн хоолны мөнгийг давхардуулан олгосон байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэсэн заалтыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь:Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

3. Гадаадад туршлага судлах арга хэмжээний зардлыг төсөвт төлөвлөөгүй атлаа нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас зориулалт бусаар байгууллагын 11 ажилтны БНХАУ-ын Жинин хотод туршлага судлах арга хэмжээний зардалд 3,850.0 мянган төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4.хуулиар зөвшөөрөөгүй бусад гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

4. Аймгийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн Б/120 дугаар захирамжаар сумын Засаг даргыг ажлаас чөлөөлөх шийдвэр гарч 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдөр ажлыг комисс хүлээлцсэн байхад 12 дугаар сард ажилласан хугацааны цалин 840.7 мянган төгрөгийг дутуу олгож, цалинг шинээр томилогдсон Засаг даргад томилсон өдрөөс эхлэн тооцож дээрх дүнгээр илүү олгосон байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

Албан шаардлага

Засаг даргын нөөц хөрөнгөөс эрдэм шинжилгээний хурлын эх бэлтгэл, ойн эмхэтгэлд 10,000.0 мянган төгрөг, улс, аймгийн аварга малчдад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээнд 9,000.0 мянган төгрөг, соёлч өрхийн шагналд 6,300.0 мянган төгрөг, аймгийн аварга шалгаруулах тэмцээнд оролцсон тамирчдын дэмжлэгт 4,500.0 мянган төгрөг, цагаан сарын баяр, нутгийн зөвлөлийн золгуутад 2,674.0 мянган төгрөг, шатахууны зардалд 1,945.6 мянган төгрөг, монгол цэргийн өдөрт зориулсан арга хэмжээнд 750.0 мянган төгрөг, нийт 35,131.6 мянган төгрөгийг үр ашиггүй зарцуулсан нь Төсвийн тухай

хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", 15.1.5-т "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал хавсралт "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1-т "Төсвийн захирагч нөөц хөрөнгийн санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна" гэж заасантай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засаг даргын нөөц хөрөнгөөс зориулалт бусаар зарцуулж буй зөрчлийг арилгах, албан шаардлага хүргүүлсэн.

2. Таван сайхан скайлайн ХХК-д 17,000.0 мянган төгрөгийг урсгал зардлаас, 4,000.0 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн данснаас шилжүүлэн Land 100 маркийн ГАА80-52 улсын дугаартай автомашины моторын ээлж солих ажлын хөлс, сэлбэг, засвар үйлчилгээ хийлгэсэн ч ажлын баримтад байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн шийдвэр байхгүй, нярвын тайланд орлого аваагүй шууд зардлаар бүртгэсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана." 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.1-т "Эзэмшилдээ байгаа илүүдэл буюу ашиглах хугацаа дууссан, шаардлага хангахгүй болсон эд хөрөнгийг худалдах, шилжүүлэх, устгахдаа эд хөрөнгийн талаар өмч хамгаалах Байнгын зөвлөл дүгнэлт гаргасан байх;" гэж заасантай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвөөс автомашинд зарцуулсан сэлбэг, урсгал засвар, зарцуулалтад хяналтыг хэрэгжүүлэн байгууллагын өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцэн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

3. Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас ойн арга хэмжээнд хандив өгсөн иргэдэд хүндэтгэл үзүүлэхэд 7,565.5 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", 15.1.5-т "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал хавсралт "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1-т "Төсвийн захирагч нөөц хөрөнгийн санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу

зарцуулна" гэж заасантай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засаг даргын нөөц хөрөнгөөс зориулалт бусаар зарцуулж буй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

4. Сумын 100 жилийн ойн арга хэмжээний арга хэмжээний зардлаас хүндэтгэлийн хүлээн авалтын хоол, бараа, хүнсний материал нийлүүлэх, зочидод хоол бэлтгэх ажлыг гүйцэтгүүлэхээр Энх ингүмэл Эс И Эй Эс ХХК-тай 11,300.0 мянган төгрөгийн, 2 иргэн 37,000.0 мянган төгрөгийн гэрээ байгуулан мөнгийг олгосон ч зарцуулалтын тайлан, ойн комиссын хэлэлцсэн ажлын тайлан байхгүй, зарцуулалтад бүрэн хяналт тавьж ажиллаагүй, үр ашиггүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй бөгөөд зохистой, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нэмэлт санхүүжилтийн данснаас ойн арга хэмжээнд зарцуулсан зарцуулалтын тайланг олон нийтээр хэлэлцүүлж, гүйцэтгэлийг баталгаажуулан зөрчлийг арилгах, албан шаардлага хүргүүлэв.

5. Цахим дэлгүүрээс 16,528.1 мянган төгрөгийн компьютер тоног төхөөрөмжийг худалдан аваагүй нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно", 14.5-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар зарлана" гэж заасантай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авсан зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

6. Шилэн дансны цахим хуудсанд 1,819,357.7 мянган төгрөгийн 81 мэдээлэл байршуулахаас цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 191,464.0 мянган төгрөгийн 20, орлогын 158,016.9 мянган төгрөгийн 7 гүйлгээг мэдээлээгүй, 245,559.5 мянган төгрөгийн 4 гүйлгээг хугацаа хоцроосон, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах гэрээний 1 мэдээлэл, тендер шалгаруулалт худалдан авалттай холбоотой 1 мэдээлэл, байгууллагын дараа жилийн төсвийн төслийн 1 мэдээллийг байршуулаагүй, хуулийн хэрэгжилт 83.0 хувьтай байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалтуудтай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй мэдээллийг нөхөн мэдээлэх албан шаардлага хүргүүлэв.

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодогч бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд нягтлан бодогч санхүүгийн тайланд өглөг, авлагыг зөрүүтэй тусгасан, хөрөнгийг бөөн дүнгээр орлого авсан, байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн шийдвэргүй автомашинд урсгал засвар хийж, сэлбэг худалдан авч зарцуулсан, ойн арга хэмжээний зарцуулалтын тайланг бүрэн гаргаагүй үр дүнг хэлэлцсэн шийдвэргүй байхад нягтлан бодох бүртгэлд тусгасан. нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана." 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.1-т "Эзэмшилдээ байгаа илүүдэл буюу ашиглах хугацаа дууссан, шаардлага хангахгүй болсон эд хөрөнгийг худалдах, шилжүүлэх, устгахдаа эд хөрөнгийн талаар өмч хамгаалах Байнгын зөвлөл дүгнэлт гаргасан байх

Өгсөн зөвлөмж: Удирдлагаас нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд тавих дотоод хяналтыг сайжруулж, байгууллагын өмч хамгаалах зөвлөлөөс хөрөнгийн хөдлөл өөрчлөлтөд байнгын хяналтаа хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж хүргүүлсэн.

Илрүүлэлт:

Тус байгууллага нь батлагдсан төсвийг 14,300.0 мянган төгрөгөөр дутуу авсан атлаа санхүүгийн тайланд авлагын 9,524.4 мянган, өглөгийн 42,108.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" 22 дугаар зүйлийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалт " Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайланд тусгагдсан авлага, өглөгийг барагдуулж арга хэмжээ авч ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлэе.

ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Алдааны утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс: | | | | Зөвлөмж | |
|--|---|------------|----------|-----------------------------------|-----|--------------------------|----------|------------|----------|--------------|-----|---------|-----|
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Залруулсан | | Залруулаагүй | | Тоо | Дүн |
| | | | | | | | | тоо | Дүн | тоо | Дүн | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 |
| Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газар | Нийгмийн даатгалын хэлтэст төлөх шимтгэлийн өглөг 33,641.мянган төгрөгийг санхүүгийн тайланд тусгаагүй | 1 | 33,341.4 | - | - | 1 | 33,341.4 | 1 | 33,341.4 | - | - | - | - |
| | Ажиллагсдын цалингаас суутган тооцсон ХХОАТ-ийн 6,980.0 мянган төгрөгийг дутуу төлсөн ч өглөгөөр тусгаагүй | 1 | 6,980.0 | - | - | 1 | 6,980.0 | 1 | 6,980.0 | - | - | - | - |
| | Алтай Улиастай Эрчим хүчний систем ТӨХК-д цахилгааны 12 дугаар сарын төлбөрийг нэхэмжилсэн 1487.4 мянган төгрөгийг төлөөгүй, тайланд өглөгөөр тусгаагүй | 1 | 1,487.4 | - | - | 1 | 1,487.4 | 1 | 1,487.4 | - | - | - | - |
| | Агнуур судлалын нийгэмлэг нь "Агнуурын менежментийн төлөвлөгөөг шинэчлэх ажлыг гүйцэтгэх" гэрээний дагуу 6,000.0 мянган төгрөгийг олгосон ч урьдчилан гарсан зардлаар бүртгээгүй | 1 | 6,000.0 | - | - | 1 | 6,000.0 | 1 | 6,000.0 | - | - | - | - |
| | Хансан панзат ХХК-ын ариун цэврийн байгууламжийн төлбөрийг гэрээний дагуу 24,995.6 мянган төгрөгийг бүрэн төлсөн байхад тайланд 7,458.7 мянган төгрөгийн өмнөх онд төлсөн мөнгөн дүнг өглөгтэйгөөр тайлагнасан. | 1 | 7,458.7 | - | - | 1 | 7,458.7 | 1 | 7,458.7 | - | - | - | - |
| | Сумын ОНХС-гийн хөрөнгөөр худалдан авсан 9,700.0 мянган төгрөгөөр унаач хүүхдүүд, бөхийн засуулын хувцсыг тусгай зориулалтын бараа материалд бөөн дүнгээр бүртгэсэн | 1 | 9,700.0 | - | - | 1 | 9,700.0 | 1 | 9,700.0 | - | - | - | - |
| | Шатахууны орлогоос 6,217.2 мянган төгрөгийн орлогыг тайланд бөөн дүнгээр тайланд тусгасан | 1 | 6,217.2 | - | - | 1 | 6,217.2 | 1 | 6,217.2 | - | - | - | - |
| | Сэлбэг материалын дансанд барилгын материалыг орлого авч зарлага гаргаж мэдээллийг буруу илэрхийлсэн | 1 | - | - | - | 1 | - | 1 | - | - | - | - | - |

Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

| | | | | | | | | | | | | | |
|--|--|------------------|----------|----------|-----------|------------------|-----------|------------------|----------|----------|----------|----------|---|
| Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газар | Худалдан авсан 8,000.0 мянган төгрөгийн төмөр 4 самбарыг үндсэн хөрөнгөд бүртгээгүй, тусгай зориулалтын бараа материалын дансанд орлого авсан | 1 | 8,000.0 | - | - | 1 | 8,000.0 | 1 | 8,000.0 | - | - | - | - |
| | Нэмэлт санхүүжилтийн данснаас Мөнгөн тахилт ХХК-д илүү шилжүүлсэн 400.0 мянган төгрөгийг буцааж дансанд орж ирсэн мөнгийг МГ, ҮД-ийн тайланд орлогоор бүртгэж, тайланг буруу илэрхийлсэн | 1 | 400.0 | - | - | 1 | 400.0 | 1 | 400.0 | - | - | - | - |
| | Хөрөнгийн бүртгэлд бүртгэлтэй Land 100 ГАА80-52 автомашины моторын ээлж сольж, засвар үйлчилгээ хийлгэхэд нийт 17,000.0 мянган төгрөгийг зарцуулсан ч тайланд өртгийг нэмэгдүүлэн капиталжуулж бүртгээгүй зардлаар тайлагнасан | 1 | 17,000.0 | - | - | 1 | 17,000.0 | 1 | 17,000.0 | - | - | - | - |
| | Сумын 100 жилийн ойгоор иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас хандивласан жагсаалтаар хүлээн авсан 83,946.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг тайланд орлого аваагүй | 1 | 83,946.0 | - | - | 1 | 83,946.0 | 1 | 83,946.0 | - | - | - | - |
| | Аймгийн ОНХС-гаас эрх шилжиж ирсэн хөрөнгө оруулалтын оролцооны 28,000.0 мянган төгрөгийн 2 худгийг хөрөнгөд орлого авахдаа бусад үнэ төлбөргүй орлогоор бүртгэж, тайланд орлого зардлыг нэмэгдүүлэн буруу тайлагнасан | 1 | 28,000.0 | - | - | 1 | 28,000.0 | 1 | 28,000.0 | - | - | - | - |
| | Дүзэ Назо ХХК-тай үүссэн халаалтын зардлын нэхэмжилсэн, тооцоо нийлж актаар баталгаажуулсан 21,665.6 мянган төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүй байна. | 1 | 21,665.6 | - | - | 1 | 21,665.6 | 1 | 21,665.6 | - | - | - | - |
| Дүн | 14 | 230,496.3 | - | - | 14 | 230,496.3 | 14 | 230,496.3 | - | - | - | - | |

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Алдаа, зөрчлийн товч утга | Нийт алдаа, зөрчлийн дүн | | Үүнээс: | | | | | | | |
|--|--|--------------------------|----------|---------------|---------|-----------------|----------|---------|-----|---|-----|
| | | Тоо | Дүн | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн | |
| | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газар | Ажиллагсад олгосон урьдчилгаа цалингаас 500,0 мянган төгрөгийг дутуу суутгасан, өмнөх оны цалингийн урьдчилгааны 1,500.0 мянган төгрөгийг суутган тооцоогүй, ажилтнаас авах 2,024.4 мянган төгрөгийн нөхөн төлбөрийг төсөвт төвлөрүүлээгүй байна. | 1 | 4,024.4 | 1 | 4,024.4 | - | - | - | - | - | - |
| | Албан хаагчдад 567.0 мянган төгрөгийн хоолны мөнгийг давхардуулан олгосон. | 1 | 567.0 | 1 | 567.0 | - | - | - | - | - | - |
| | Гадаадад туршлага судлах арга хэмжээний зардлыг төсөвт төлөвлөөгүй атлаа нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас зориулалт бусаар байгууллагын 11 ажилтны БНХАУ-ын Жинин хотод туршлага судлах арга хэмжээний зардалд 3,850.0 мянган төгрөгийг зарцуулсан | 1 | 3,850.0 | 1 | 3,850.0 | - | - | - | - | - | - |
| | Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас ойн арга хэмжээнд хандив өгсөн иргэдэд хүндэтгэл үзүүлэхэд 7,565.5 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан. | 1 | 7,565.5 | - | - | 1 | 7,565.5 | - | - | - | - |
| | Сумын өмнөх Засаг даргын 12 дугаар сард ажилласан цалинг 840.7 мянган төгрөгөөр дутуу олгож, шинээр томилогдсон Засаг даргад томилсон өдрөөс эхлэн тооцож тус дүнгээр илүү олгосон байна. | 1 | 840.8 | 1 | 840.8 | - | - | - | - | - | - |
| | Засаг даргын нөөц хөрөнгөөс эрдэм шинжилгээний хурлын эх бэлтгэл, ойн эмхэтгэлд 10,000.0 мянган төгрөг, улс, аймгийн аварга малчдад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээнд 9,000.0 мянган төгрөг, соёлч өрхийн шагналд 6,300.0 мянган төгрөг, аймгийн аварга шалгаруулах тэмцээнд оролцсон тамирчдын дэмжлэгт 4,500.0 мянган төгрөг, цагаан сарын баяр, нутгийн зөвлөлийн золгуут арга хэмжээнд 2,674.0 мянган төгрөг, шатахууны зардалд 1,945.6 мянган төгрөг, монгол цэргийн өдөрт зориулсан арга хэмжээнд 750.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна. | 1 | 35,131.6 | - | - | 1 | 35,131.6 | - | - | - | - |

Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

| | | | | | | | | | | | | |
|--|---|-----------|------------------|----------|----------------|----------|------------------|----------|----------|----------|----------|---|
| | Таван сайхан скайлайн ХХК-д 17,000.0 мянган төгрөгийг урсгал зардлаас, 4,000.0 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн данснаас шилжүүлэн Land 100 маркийн ГАА80-52 улсын дугаартай автомашины моторын ээлж солих ажлын хөлс, сэлбэг, засвар үйлчилгээ хийлгэсэн ч ажлын баримтад байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн шийдвэр байхгүй, нярвын тайланд орлого аваагүй шууд зардлаар бүртгэсэн. | 1 | 21,000.0 | - | - | 1 | 21,000.0 | - | - | - | - | |
| Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газар | Тайлант онд нягтлан бодогч санхүүгийн тайланд өглөг, авлагыг зөрүүтэй тусгасан, хөрөнгийг бөөн дүнгээр орлого авсан, байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн шийдвэргүй автомашинд урсгал засвар хийж, сэлбэг худалдан авч зарцуулсан, ойн арга хэмжээний зарцуулалтын тайланг бүрэн гаргаагүй үр дүнг хэлэлцсэн шийдвэргүй байхад нягтлан бодох бүртгэлд тусгасан байна | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - | |
| | Тус байгууллага нь батлагдсан төсвийг 14,300.0 мянган төгрөгөөр дутуу авсан атлаа санхүүгийн тайланд авлагын 9,524.4 мянган, өглөгийн 42,108.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. | 1 | - | - | - | - | - | - | 1 | - | - | - |
| | Сумын 100 жилийн ойн арга хэмжээний арга хэмжээний зардлаас хүндэтгэлийн хүлээн авалтын хоол, бараа, хүнсний материал нийлүүлэх, зочидод хоол бэлтгэх ажлыг гүйцэтгүүлэхээр Энх ингүмэл Эс И Эй Эс ХХК-тай 11,300.0 мянган төгрөгийн, иргэн Г.Адилбиштэй 18,000.0 мянган төгрөгийн, Т.Алтантуяатай 19,000.0 мянган төгрөгийн гэрээ байгуулан мөнгийг олгосон ч зарцуулалтын тайлан, ойн комиссын хэлэлцсэн ажлын тайлан байхгүй, зарцуулалтад бүрэн хяналт тавьж ажиллаагүй, үр ашиггүй зарцуулсан байна. | 1 | 48,300.0 | - | - | 1 | 48,300.0 | - | - | - | - | |
| | Тайлант онд 16,528.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмж компьютер бэлтгэхдээ цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна | 1 | 16,528.1 | - | - | 1 | 16,528.1 | - | - | - | - | |
| Нийт | | 11 | 137,807.4 | 4 | 9,282.2 | 5 | 128,525.2 | 2 | - | - | - | |

4.3 Нийцлийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Алдаа, зөрчлийн товч утга | Нийт алдаа, зөрчлийн дүн | | Үүнээс: | | | | | | | |
|--|---|--------------------------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|-----|---|-----|
| | | Тоо | Дүн | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн | |
| | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газар | Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 191,464.0 мянган төгрөгийн 20, орлогын 158,016.9 мянган төгрөгийн 7 гүйлгээг мэдээлээгүй, 245,559.5 мянган төгрөгийн 4 гүйлгээг хугацаа хоцроосон, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах гэрээний 1 мэдээлэл, тендер шалгаруулалт худалдан авалттай холбоотой 1 мэдээлэл, байгууллагын дараа жилийн төсвийн төслийн 1 мэдээллийг байршуулаагүй байна. | 1 | - | - | - | 1 | - | - | - | - | - |
| дүн | | 1 | - | - | - | 1 | - | - | - | - | - |

ТАВ. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|-----------------------------|--------------------------|-----------------------------|--------------------|-----------------|-------------------------|----------------|-------|----------------------------|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | Өөрчлөлтгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | | | | |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | | 1 | | |
| | НИЙТ | 1 | 1 | | | | 1 | | |